



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 07 сарын 18 өдөр

Дугаар A/547

Булган сум

Захирамжийн зарим хэсгийг  
хүчингүй болгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.11, 66 дугаар зүйлийн 66.1, Газрын тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1, Газар зохион байгуулалт, геодези зураг зүйн газрын 2021 оны А/187 дугаар тушаалаар батлагдсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ олгох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Д.Лхагважавт газар эзэмшүүлж буй тал нь гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйн улмаас иргэн уг газраа зориулалтын дагуу ашиглах боломжгүй байсан болох нь зохих баримтаар нотлогдож байгаа тул Орхон сумын Засаг даргын 2023 оны 5 дугаар сарын 15-ны А/125 дугаар захирамжийн Д.Лхагважавт холбогдох хэсгийг хүчингүй болгосугай.

2. Үйл ажиллагаандаа хууль тогтоомжийг чанд мөрдөн, хүний эрх, эрх чөлөөг дээдлэн ажиллахыг Орхон сумын Засаг дарга (Н.Амартүвшин)–д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ.

6323030531